


## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### *“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан*



**Шилэн дансны тухай хуулийг холбогдох албан тушаалтнууд бүрэн  
хэрэгжүүлээгүй байна**

**Улаанбаатар хот  
2017 он**

## Агуулга

### Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар

НАГ-ын захирал  
бөгөөд Тэргүүлэх  
аудитор Б.Алтанзул

Ахлах аудитор  
Д.Отгонбаяр

Аудитор  
Ц.Цэрэннамжил  
Д.Дорждулам  
С.Сугармаа

2017 оны 12 дугаар  
сар

Тайланг ҮАГ-ын веб  
сайт-аас үзнэ үү.  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитын тайлан,  
дүгнэлттэй  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах,  
асууж лавлах зүйл  
байвал 261729  
дугаарын утас,  
260949 дугаарын  
факсаар  
харилцана уу.

**Хаяг:**  
Үндэсний аудитын  
газар  
Засгийн газрын 4  
дүгээр  
байр,  
Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг,

|                                |     |
|--------------------------------|-----|
| Товчилсон үгийн жагсаалт ..... | 4   |
| Аудит хийх үндэслэл.....       | 5   |
| Аудитын зорилт.....            | 5   |
| Аудитын хамрах хүрээ.....      | 5   |
| Аудитын арга зүй.....          | 5-6 |
| Үндсэн мэдээлэл.....           | 7   |

### БҮЛЭГ 1. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАС БОЛОН БАЙГУУЛЛАГУУДЫН ӨӨРИЙН ЦАХИМ ХУУДСАНД ОРУУЛАХ МЭДЭЭЛЛИЙН ДАВХАРДЛЫГ АРИЛГАЖ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....

8-10

1.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн  
3.1.4-3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны  
нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаагүй байна..

8-9

1.2. Шилэн дансны тухай хууль болон Шилэн дансны  
цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг  
стандартыг тогтоох журамд нэмэлт, өөрчлөлт  
оруулах шаардлагатай байна.....

9-10

### БҮЛЭГ.2 ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ШААРДЛАГАТАЙ БАЙНА .....

11-15

2.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн  
3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн  
6.1 дэх хэсэгт заасан мэдээллийг бүрэн  
байршуулаагүй байна .....

11

2.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн  
3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд хуулийн 6 дугаар  
зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан мэдээллийг бүрэн  
байршуулаагүй байна .....

11-13

2.3. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн  
захиргааны төв байгууллага хуулийн 6 дугаар  
зүйлийн 6.5 дахь хэсэгт заасан мэдээллийг дутуу,  
хугацаанд мэдээлээгүй зөрчилтэй байна.....

13-14

2.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн  
3.1.3 дахь заалтад хамаарах аж ахуй нэгж,

Улаанбаатар 15160,  
Монгол улс

|                                                                                                                                                                                           |       |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй байна .....                                                                                                                     | 14-15 |
| 2.5. Хуулийн 3.1.4, 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулаагүй байна .....                                                                               | 15    |
| <b>БҮЛЭГ 3. ШИЛЭН ДАНСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....</b>                                                                                                     | 16-19 |
| 3.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал хөндлөнгийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж байна .....                 | 16    |
| 3.2. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан ТЭЗ-ийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан хаагчдад шилэн дансны сургалт явуулах шаардлагатай байна.....              | 17    |
| 3.3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг тусгасан хэдий ч үр дүн гарахгүй байна..... | 17-18 |
| 3.4. Иргэн хуулийн этгээдээс хуулийн хэрэгжилттэй холбоотой санал, гомдол ирүүлээгүй байна.....                                                                                           | 18-19 |
| <b>БҮЛЭГ 4. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА .....</b>                                                                                                          | 19    |
| 4.1. Өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн хэдий ч зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна .....                                                                        | 19    |
| Дүгнэлт.....                                                                                                                                                                              | 20-21 |
| Зөвлөмж.....                                                                                                                                                                              | 22    |
| Холбогдох байгууллагын санал.....                                                                                                                                                         |       |
| МУЕА-ын тушаал.....                                                                                                                                                                       |       |
| Хавсралтууд.....                                                                                                                                                                          |       |

## Товчилсон үгийн жагсаалт

|                 |                                                      |
|-----------------|------------------------------------------------------|
| <b>ААНБ</b>     | Аж ахуйн нэгж, байгууллага                           |
| <b>АДБОУС</b>   | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт     |
| <b>БСШУЯ</b>    | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам                  |
| <b>БОАЖЯ</b>    | Байгаль орчин аялал жуулчлалын яам                   |
| <b>ЗГХЭГ</b>    | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар                    |
| <b>ЗТХЯ</b>     | Зам тээврийн хөгжлийн яам                            |
| <b>ИНХ</b>      | Иргэдийн Нийтийн Хурал                               |
| <b>ИТХ</b>      | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                         |
| <b>НАГ</b>      | Нийцлийн аудитын газар                               |
| <b>МУЕС</b>     | Монгол Улсын Ерөнхий сайд                            |
| <b>МУШС</b>     | Монгол Улсын шадар сайд                              |
| <b>ОНӨААТҮГ</b> | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| <b>ОНӨҮГ</b>    | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар                  |
| <b>СЯ</b>       | Сангийн яам                                          |
| <b>ТЕЗ</b>      | Төсвийн ерөнхийлөн захирагч                          |
| <b>ТӨХК</b>     | Төрийн өмчит хувьцаат компани                        |
| <b>ТӨҮГ</b>     | Төрийн өмчит үйлдвэрийн газар                        |
| <b>ТЭДС</b>     | Тариалан эрхлэлтийг дэмжих сан                       |
| <b>ҮАГ</b>      | Үндэсний аудитын газар                               |
| <b>ҮСХ</b>      | Үндэсний статистикийн хороо                          |
| <b>ТНБД</b>     | Төрийн нарийн бичгийн дарга                          |
| <b>ТӨААТҮГ</b>  | Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар       |
| <b>ХНХЯ</b>     | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд                   |
| <b>ХЗДХЯ</b>    | Хууль зүй, дотоод хэргийн яам                        |
| <b>ХХААХҮЯ</b>  | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд          |
| <b>ХХК</b>      | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                 |
| <b>ЭХЯ</b>      | Эрчим хүчний сайд                                    |
| <b>ЭМЯ</b>      | Эрүүл мэндийн яам                                    |

### **Аудит хийх үндэслэл**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 02 дугаар тогтоолын дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

### **Аудитын зорилт**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудитыг гүйцэтгэсэн.Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, бүрэн хамрагдсан эсэх;
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх;
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх;
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

### **Хамарсан хүрээ**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2015-2016 онд хийсэн аудитын дүн, мэдээлэлд үндэслэн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт хамаарах 35 ТЕЗ, түүний харьяа 4290 байгууллагыг аудитад түүвэрлэн хамруулж, 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны хуулийн хэрэгжилтийг шалгалаа.

### **Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагын өөрийн цахим хуудас болон нэгдсэн цахим хуудсанд байрлуулсан мэдээллийг дансны хуулга, холбогдох тушаал, шийдвэр, гэрээтэй тулган шалгах аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

### **Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт**

- Шилэн дансны тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Холбогдох бусад хууль, дүрэм, журам.

### **Үндсэн мэдээлэл**

Сангийн яамнаас ирүүлсэн судалгаагаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2017 онд нийт 141,028 хэрэглэгч 375,633 удаагийн хандалт хийж, хоёр сая мэдээлэлтэй танилцсан байна.

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн бөгөөд Төрийн аудитын байгууллагаас хуулийн хэрэгжилтэд 2015, 2016 онуудад тус бүр 2 удаа аудит хийж, дүнг тайлагнасан болно.

Тус аудитаар төлөвлөгөөнд тусгагдсан аудитын зорилт, дэд зорилтуудын дагуу хуулийн 3 дугаар зүйлд хамаарах байгууллага, албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн мэдээлсэн эсэхэд хяналт тавихаас гадна бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, иргэдийн Нийтийн хурал, иргэдээс хяналт тавьсан байдал, байгууллага, албан тушаалтны ажлын үр дүнг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ хуулийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт болгож байгаа эсэх болон өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн анхаарч үзлээ.

Аудитад улсын төсвийн 13 ТЕЗ, тэдгээрийн харьяа 724 байгууллага, аймаг нийслэлийн 22 ТЕЗ, тэдгээрийн харьяа 4256 байгууллага буюу нийт 4980 байгууллагыг түүвэрлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгалаа.

Тус аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 13 ТЕЗ, тэдгээрийн харьяа 724 байгууллага дунджаар 94.7 хувь, аймаг, нийслэлийн 22 ТЕЗ, тэдгээрийн харьяа 4256 байгууллага дунджаар 88.9 хувьтай хэрэгжүүлсэн нь 2016 оны 4 дүгээр улиралд гүйцэтгэсэн аудитын дүнгээс улсын төсвийн ТЕЗ тэдгээрийн харьяа байгууллагуудын хэрэгжилт 2.7 хувиар буурсан байхад, аймаг, нийслэлийн 22 ТЕЗ тэдгээрийн харьяа байгууллагуудын хуулийн хэрэгжилт 1.4 хувиар өссөн байна. (Хавсралт №1, №2-д үзүүлэв)

Аудитын явцад илэрсэн зөрчилд тухай бүр залруулга хийлгэж ажилласнаас гадна нийт байгууллагад 72 хариуцлага тооцуулах, 415 зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

**БҮЛЭГ.1 ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАС БОЛОН БАЙГУУЛЛАГУУДЫН ӨӨРИЙН ЦАХИМ ХУУДСАНД ОРУУЛАХ МЭДЭЭЛЛИЙН ДАВХАРДЛЫГ АРИЛГАЖ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4<sup>1</sup>-3.1.5<sup>2</sup>-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаагүй байна**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1<sup>3</sup>, 3.1.2<sup>4</sup>, 3.1.3<sup>5</sup>-т хамаарах төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, ТӨҮГ, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанийн нийт 6321 цэс нэгдсэн цахим хуудсанд нээгдэж, мэдээлэл байршуулах боломжоор хангагдсан байна.

Аудитад улсын төсвийн 13 ТЕЗ, түүний харьяа 724 байгууллага, аймаг нийслэл дэх 22 ТЕЗ, түүний харьяа 4256 байгууллага, нийт 35 ТЕЗ, тэдгээрийн харьяа 4980 байгууллагыг түүвэрлэн шалгахад тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-т хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан хэдий ч байгууллага татан буугдсан байхад бүртгэлээс хасагдаагүй, зарим байгууллагын цэс давхар үүсгэгдсэн байна. *Тухайлбал:*

- Говьсүмбэр аймгийн ТЕЗ-ийн харьяанд Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Сүмбэр сумын Өрхийн эрүүл мэндийн газрын цэс илүү үүсгэгдсэн;
- Тус аймгийн Насан туршийн боловсролын төв болон Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс татан буугдсан байхад бүртгэлийг шинэчлээгүй;
- Архангай аймгийн Ихтамир, Эрдэнэмандал сумын ойн анги татан буугдсан байхад бүртгэлийг шинэчлээгүй;
- Дундговь аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Улсын нөөцийн салбар татан буугдсан байхад бүртгэлийг шинэчлээгүй;
- Хөвсгөл аймгийн сумдад үйл ажиллагаа явуулдаг уурын зуух, эмийн эргэлтийн сангууд ХХК болж, өмчийн хэлбэр өөрчлөгдсөн байхад харьяа ТЕЗ-ийн дотоод аудитын албанаас тухай бүр Сангийн яаманд хандаж бүртгэлийг шинэчлээгүй байна.

Цаашид шинээр үүсгэн байгуулагдаж байгаа болон татан буугдсан байгууллагуудыг шилэн дансанд бүртгэх, бүртгэлийг шинэчлэх, тэдгээрт хяналт тавихтай холбоотой харилцааг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-аар зохицуулах шаардлагатай байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д хамаарах 1206 байгууллагын цэс үүсгэгдсэнээс үйл ажиллагаа явуулсан эсэх нь тодорхойгүй 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах 382 аж ахуй нэгж, байгууллага бүртгэлтэй байна. Бүртгэл хангалтгүй аймгуудыг графикаар харуулбал:


<sup>1</sup> Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж, байгууллага

<sup>2</sup> Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч

<sup>3</sup> Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

<sup>4</sup> Төрийн өмчийн үйлдвэрийн газар;

<sup>5</sup> Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;



Дээрх зөрчил нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аж ахуй нэгж байгууллагын цэс үүсгэх, мэдээлэл байршуулах үүргийг ажил үйлчилгээ гүйцэтгүүлж буй гэрээнд тусгаж, санхүүжилт олгосон байгууллагаас хяналт тавих харилцааг хууль болон холбогдох журамд нарийвчлан зохицуулаагүйтэй холбоотой байна.

**1.2. Шилэн дансны тухай хууль болон Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.**

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэнэ” гэж заасан байхад аудитад хамрагдсан байгууллагууд өөрийн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй, зарим байгууллага өөрийн цахим хуудас дахь цэсийг нэгдсэн цахим хуудсанд холбосон байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын өөрийн цахим хуудсанд байршуулсан мэдээллээс үзэхэд хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1<sup>6</sup>, 4.1.2<sup>7</sup>, 4.1.3<sup>8</sup>-д заасан зарчмын шаардлагыг дараах шалтгаанаар хангахгүй, олон нийтийн зүгээс мэдээлэлтэй танилцах болон хөндлөнгийн хяналтын байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэсэн байна. Тухайлбал:

- цахим хуудасны хөгжүүлэлт хангалтгүйгээс мэдээлэл цэгцгүй, ойлгомжгүй;
- шилэн дансны нэгдсэн цахим хуудсандай давхардуулан мэдээлдэг нь ажлын ачаалал үүсгэж, байгууллагын цахим хуудсанд мэдээлэл дутуу байршигддаг;
- байгууллага худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар давхар мэдээлдэгээс ажлын ачаалал үүсгэж, мэдээлэл дутуу байршигддаг;

<sup>6</sup> “... иж бүрэн байх”

<sup>7</sup> “мэдээлэл ойлгомжтой, ...”

<sup>8</sup> Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;

- мэдээлэх үүрэг хүлээсэн албан тушаалтнууд өөрийн цахим хуудсанд мэдээлэл байршуулах мэдлэг, ур чадваргүй байгаагаас мэдээллийн технологийн мэргэжилтнээр дамжуулан мэдээллээ байршуулж байгаа нь хуулийн шаардлага хангахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэсийг байгууллагууд өөрийн цахим хуудсанд холбох, [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягт байршуулж буй мэдээлэл нэгдсэн цахим хуудсанд давхар мэдээлэгддэг байх эрх зүйн зохицуулалтыг Шилэн дансны тухай хууль, холбогдох журамд тусгах шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллага, албан тушаалтны цахим хуудсанд мэдээлэл тавихтай холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулж буй “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам” нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1<sup>9</sup>, 60.1.2<sup>10</sup>, 60.1.8<sup>11</sup>-д заасан захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагад нийцээгүй байна. Тухайлбал:

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5-д заасан заалтыг давхардуулан зохицуулсан;
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т тендерийн урилгыг мэдээлэхээр заасан байхад журамд нарийвчилсан зохицуулалт тусгаагүй, нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх цонх байхгүй байна;
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1<sup>12</sup>, 6.8.2<sup>13</sup>, 6.8.3<sup>14</sup>-т хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэр мэдээлэхээр хуульчлаагүй байхад журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3<sup>15</sup>-т мэдээлэхээр зааж, хуульд заагаагүй үүрэг хүлээлгэн нэгдсэн цахим хуудсанд мэдээлэхээр журамласан нь төр, орон нутгийн өмчийн оролцоотой компаниуд зах зээлд давуу байдлаа хамгаалахад сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам, хэлбэрийг” тогтоохоор заасан байхад тус журмаар цахим хуудасны стандарт, хэлбэрийг тодорхойлоогүй байна.

Иймд “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг Шилэн дансны тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

<sup>9</sup> Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх;

<sup>10</sup> тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх;

<sup>11</sup> бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх

<sup>12</sup> тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр;

<sup>13</sup> худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

<sup>14</sup> төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт;

<sup>15</sup> “... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр ...”

## **БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГУУД ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН БАЙРШУУЛДАГҮЙ НИЙТЛЭГ ЗӨРЧЛИЙГ ГАРГАСААР БАЙНА**

**2.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1<sup>16</sup>, 3.1.2<sup>17</sup>-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1<sup>18</sup> дэх хэсэгт заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна**

Аудитад улсын төсвийн 13 ТЕЗ, түүний харьяа 724 төрийн байгууллага, аймаг, нийслэлийн 22 ТЕЗ, тэдгээрийн харьяа 4256 төрийн байгууллага буюу нийт 4980 байгууллагыг хамруулан, тэдгээрийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийг холбогдох тайлан, баримт материал, нотлох зүйлстэй тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- 6.1.1-д заасан тухайн жилийн төсвийг 515 байгууллага буюу 10.6 хувь нь мэдээлээгүй;
- 6.1.2-т заасан төсвийн гүйцэтгэлийг 12 сарын дунджаар 212 байгууллага буюу 4.4 хувь нь мэдээлээгүй;
- 6.1.3-т заасан дараа жилийн төсвийн төслийг 1058 байгууллага буюу 22.1 хувь нь мэдээлээгүй;
- 6.1.4-т заасан хагас жилийн санхүүгийн тайланг 612 байгууллага буюу 13.8 хувь, бүтэн жилийн санхүүгийн тайланг 897 байгууллага буюу 20.8 хувь нь мэдээлээгүй;
- 6.1.5-т заасан ТЕЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 726 байгууллага буюу 21.9 хувь, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 943 байгууллага буюу 28.8 хувь нь мэдээлээгүй;
- 6.1.6-т заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарыг 928 байгууллага буюу 20.4 хувь нь тус тус мэдээлээгүй байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарах төсөл хэрэгжүүлэгч нэгж, 3.1.2-т хамаарах улсын төсвийн байгууллагуудын харьяалах дээд байгууллагуудаас нь төсвийг чанарын болон тоон шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгээр нарийвчлан баталдаггүй, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийг төсвийн бусад байгууллагуудын нэгэн адил сар тутам гаргадаггүй тул шилэн дансны цахим хуудсанд оруулах мэдээлэл, түүний агуулгыг тэдгээрийн онцлогт нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй, дутуу мэдээлсэн 218 төрийн байгууллага, ТӨҮГ-ын эрх бүхий албан тушаалтанд зөрчил арилгуулах тухай 216, сахилгын шийтгэл ногдуулах тухай 2 албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д хамаарах “Монгол тамга” ТӨҮГ болон “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨҮГ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулаагүй тул сахилгын шийтгэл ногдуулах тухай албан шаардлагыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлээ.

**2.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4<sup>19</sup> дэх хэсэгт заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>20</sup>-д заасан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг Улсын төсвийн 13 ТЕЗ, тэдгээрийн харьяа мэдээлбэл зохих 361

<sup>16</sup> Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

<sup>17</sup> Төрийн өмчит үйлдвэрийн газар;

<sup>18</sup> Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ;

<sup>19</sup> Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ;

<sup>20</sup> Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;

байгууллагаас 5 байгууллага буюу 1.3 хувь, аймаг, нийслэлийн 22 ТЕЗ тэдгээрийн харьяа мэдээлбэл зохих 3612 байгууллагаас 191 буюу 5.3 хувь нь тус тус мэдээллээ байршуулаагүй байна.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2<sup>21</sup> -т заасан хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт орсон улсын төсвийн 13 ТЕЗ, түүний харьяа 25 байгууллагын 15 байгууллага, аймаг, нийслэлийн 22 ТЕЗ тэдгээрийн харьяа мэдээлвэл зохих 2784 байгууллагын 166 нь мэдээллээ байршуулаагүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3<sup>22</sup>-т заасан тендер, худалдан авалтын мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 7506 тендерийн мэдээллээс 1208 буюу 16.1 хувь нь байршуулаагүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4<sup>23</sup>-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг улсын төсвийн 13 ТЕЗ, түүний харьяа байгууллага 145.8 сая төгрөгийн 85 гүйлгээ, аймаг, нийслэлийн 22 ТЕЗ, түүний харьяа байгууллага 13,018.4 сая төгрөгийн 1788 гүйлгээ буюу 12.8 хувийг тус тус мэдээлээгүй байна.

Дээрх зөрчил нь албан хаагчид хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй, дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5<sup>24</sup>-д заасан цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг улсын төсвийн ТЕЗ, түүний харьяа байгууллагын 3908 орлогын гүйлгээнээс 156 гүйлгээг, зарлагын 5992 гүйлгээнээс 215 гүйлгээг, аймаг, нийслэлийн харьяа байгууллага орлогын 37294 гүйлгээнээс 4034 гүйлгээг, зарлагын 35973 гүйлгээнээс 2280 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6<sup>25</sup>-д заасан худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг нийт мэдээлбэл зохих 2951 байгууллагаас 198 буюу 6.7 хувь нь мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7<sup>26</sup>-д заасан байгууллагын батлагдсан орон тоонд өөрчлөлт орсон мэдээллийг нийт мэдээлбэл зохих 3405 байгууллагаас 218 буюу 6.4 хувь нь мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>27</sup>-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг улсын төсвийн 13 ТЕЗ, түүний харьяа байгууллагын нийт 934 шийдвэрээс 79.5 сая төгрөгийн 84 шийдвэр буюу 9.0 хувийг, аймаг, нийслэлийн 22 ТЕЗ, түүний харьяа

<sup>21</sup> Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;

<sup>22</sup> Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

<sup>23</sup> Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

<sup>24</sup> Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

<sup>25</sup> Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;

<sup>26</sup> Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;

<sup>27</sup> Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

байгууллагын 25785 шийдвэрээс 23,687.9 сая төгрөгийн 5981 шийдвэр буюу 23.2 хувийг мэдээлээгүй байна. Тухайлбал:

- ЗТХ-ийн сайдын төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 63 шийдвэр;
- ЭХЯ-ны харьяа “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТГ-ын төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 27 тушаал, 7 гэрээ;
- БОАЖЯ-ны харьяа Цаг уур, орчны шинжилгээний газар төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 44 шийдвэр;
- Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 15 шийдвэр;
- Ойн судалгаа хөгжлийн төвийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 12 шийдвэр;
- Булган аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 10, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 10 шийдвэр;
- Дорноговь аймгийн Засаг даргын төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 12 шийдвэр;
- Орхон аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 20, 7-р сургуулийн 11, 17 дугаар сургуулийн 10, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 11 шийдвэр;
- Нийслэлийн Засаг даргын тамгын газар төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 168 шийдвэр.

Зарим ТЕЗ-аас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхээ шилжүүлсэн болон улс, орон нутгийн төсөв болон бусад холбогдох эх үүсвэрээс санхүүжин хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тохиолдолд тендерийн мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэл байршуулах хэсэгт *“Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр”* гэсэн олон төрлийн мэдээлэл нэг дор байршигдсанаар хуулийг хэрэгжүүлж буй байгууллага ойлголтын зөрүү үүсч, зөрчил гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Аудитаар хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй, дутуу мэдээлсэн зөрчилд 117 төрийн байгууллага, 2 ТӨҮГ-т албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Монголбанк өөрийн цахим хуудас дахь шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим хуудсандай холбосон бөгөөд *“бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”* болон байгууллагын *“батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт”*-ийг мэдээлэх цэсгүй байсныг аудитын явцад залруулж, орууллаа.

### **2.3. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуулийн 6 дугаар зүйлийн 6.5<sup>28</sup> дахь хэсэгт заасан мэдээллийг дутуу, хугацаанд мэдээлээгүй зөрчил гаргасан байна**

Сангийн яам хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1-6.5.9-д заасан зарим мэдээллийг 2017 онд хугацаа хоцроож мэдээлсэн байна.

<sup>28</sup> Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана:

Мөн Сангийн сайд болон яамны аппарат шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасан зарим мэдээллийг оруулаагүй, хугацаа хоцорч мэдээлсэн байна. Тухайлбал:

- Төсөв, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой Сангийн сайдын 6 тушаал, ТНБД-ын 15 тушаалыг мэдээлээгүй;
- Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 1-9 дүгээр сард хоцроосон;
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн мэдээг 1-9 сард хоцроосон;
- Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг 1-8 дугаар сард хоцроосон;
- Мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрт эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, ашиг сонирхолын мэдүүлгийг 1-9 дүгээр сард тус тус хугацаа хоцорч мэдээлсэн.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.8-д концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдээлэхээр заасан байхад Үндэсний хөгжлийн газрын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус мэдээллийг давхардуулан цонх үүсгэснийг хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

#### **2.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3<sup>29</sup> дахь заалтад хамаарах аж ахуй нэгж, байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй байна**

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8<sup>30</sup>-д заасан мэдээллийг байршуулж байгаа боловч зарим байгууллагууд мэдээлээгүй зөрчил гаргасан байна. Тухайлбал:

- Орхон аймгийн “Эрдэнэт ус ДЦС” ОНӨХК шилэн дансны хуульд заасан мэдээллийг байршуулаагүй тул хугацаатай албан шаардлагыг хүргүүлсэн;
- “Хөгжлийн банк” нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд банкны өөрийн үйл ажиллагааны холбогдох мэдээллийг байршуулсан бөгөөд тухайн байгууллагад хамаарах Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл, төсвийн өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, их хэмжээний хэлцэлд тооцохуйц баталгаа, батлан даалт зэргийг мэдээлээгүй байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллага төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3<sup>31</sup> -т заасны дагуу мэдээлснээр компанийн зах зээлд давуу байдлаа хамгаалахад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байгаа тул холбогдох журмыг хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д нийцүүлэх шаардлагатай байна.

#### **2.5. Хуулийн 3.1.4, 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулаагүй байна**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг мэдээлээгүй, 3.1.5-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулж байгаа хэдий ч

<sup>29</sup> Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

<sup>30</sup> Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ;

<sup>31</sup> “... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр ...”

хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах хуулийн шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж, байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчийн мэдээлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан, хүлээлгэх хариуцлагыг хууль, журамд тодорхой тусгаагүйтэй холбоотой байна.

Иймд ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээнд гүйцэтгэгчийн шилэн дансанд мэдээлэх үүрэг, хариуцлагын талаар тусгах, хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан болон хүлээлгэх хариуцлагыг *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”*-д тодорхой тусгах шаардлагатай байна.

### БҮЛЭГ 3. ШИЛЭН ДАНСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

**3.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1<sup>32</sup> дэх хэсэгт заасан бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал хөндлөнгийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж байна**

Аймаг, нийслэлийн ИТХ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д, ТЭЗ хуулийн 8.2-д заасан хөндлөнгийн болон дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

| №  | Аймгийн нэр         | ИТХ-аас хяналт хийгдсэн эсэх                                     | ТЭЗ-аас хяналт хийгдсэн эсэх |
|----|---------------------|------------------------------------------------------------------|------------------------------|
| 1  | Архангай аймаг      | Тийм                                                             | Тийм                         |
| 2  | БаянӨлгий           | Үгүй                                                             | Тийм                         |
| 3  | Баянхонгор          | Үгүй                                                             | Тийм                         |
| 4  | Булган              | Тийм                                                             | Тийм                         |
| 5  | ГовьАлтай           | Үгүй                                                             | Тийм                         |
| 6  | Говьсүмбэр          | Үгүй                                                             | Тийм                         |
| 7  | Дархан-Уул          | Үгүй                                                             | Тийм                         |
| 8  | Дорноговь           | Тийм                                                             | Тийм                         |
| 9  | Дорнод              | Үгүй                                                             | Тийм                         |
| 10 | Дундговь            | Үгүй                                                             | Тийм                         |
| 11 | Завхан              | Үгүй                                                             | Тийм                         |
| 12 | Нийслэл             | Налайх дүүргийн ИТХ-аас бусад дүүргийн ИТХ хяналт хэрэгжүүлээгүй | Тийм                         |
| 13 | Орхон               | Тийм                                                             | Тийм                         |
| 14 | Өвөрхангай          | Бүрэн хэрэгжүүлээгүй                                             | Тийм                         |
| 15 | Өмнөговь            | Аймгийн ИТХ, Мандал, Хүрмэн сумын ИТХ хяналт хэрэгжүүлээгүй      | Тийм                         |
| 16 | Сүхбаатар           | Үгүй                                                             | Тийм                         |
| 17 | Сэлэнгэ             | Тийм                                                             | Тийм                         |
| 18 | Төв                 | Тийм                                                             | Тийм                         |
| 19 | Увс                 | Тийм                                                             | Тийм                         |
| 20 | Ховд                | Тийм                                                             | Тийм                         |
| 21 | Хөвсгөл             | Үгүй                                                             | Үгүй                         |
| 22 | Хэнтий              | Үгүй                                                             | Үгүй                         |
|    | <b>Дүн (хувиар)</b> | <b>36.4</b>                                                      | <b>90.9</b>                  |

